

## МОНГОЛЫН ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨВ

**Ц.Цэцэгмаа**

Докторант,  
Худалдаа, Үйлдвэрлэлийн Дээд Сургуулийн багш

*1995 оноос эхлэн Монгол улсад иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, урсгал шинжтэй байснаа зохион байгуулалттай хэлбэрт шилжин орж байна. Гэвч энэ талаарх бүртгэл мэдээллийн тогтолцооны хангалтгүй байдлаас хамааран чухам албан бус замаар хичнээн хүн гадаадад суралцаж, ажиллаж амьдарч байгаа талаар улсын хэмжээнд бодитой статистик мэдээлэл хангалтгүй байгаа юм.*

*Өнөөдөр хүн амын хамгийн хөдөлгөөнтэй хэсэг болох залуучууд, тэр тусмаа оюутнууд хилийн чанадад сурч эсвэл ажиллахыг ихээхэн сонирхох болсон нь нууц биш байна. Иймээс энэхүү ажилд, Монгол оюутнуудын гадаад шилжих хөдөлгөөний ирээдүйн төлөв байдлын талаар мэдээлэл авах зорилгоор зохиогч Монголын 12 томоохон их, дээд сургуулийн 1000 гаруй оюутнуудын дунд түүвэр судалгаа явуулсан юм. Судалгаагаар, оюутнуудын хилийн чанадад явах урсгал хөдөлгөөний өнөөгийн болон ирээдүйн төлөв байдал, түүнд нөлөөлж буй нийгэм, хүн ам зүй, гадаад орчны болон “татах” ба “түлхэх” хүчин зүйлүүд, гадаад явах суваг, очихыг сонирхож буй улс орнууд зэрэг олон чухал мэдээллийг гаргаж авсан болно. Уншигч та энэ талаарх дэлгэрэнгүй үр дүнтэй доорх бүтээлээс танилцана уу.*

### Оршил

**Шилжих хөдөлгөөн** гэдэг нь хүн ам байнга оршин суух газраа засаг захиргааны нэгж хооронд сэлгэн, өөрчлөх процесс юм. Хүн амын шилжих хөдөлгөөнийг ямар нэг улсын хилийг давсан эсэхээс хамааран дотоод ба гадаад (эсвэл олон улсын) гэж ангилдаг.

Дотоод шилжих хөдөлгөөн гэдэг нь улсын дотор, нэг засаг захиргааны нэгжээс нөгөөд шилжин суурьшихийг хэлнэ.

Гадаад шилжих хөдөлгөөн гэдэг нь түр зуур болон байнга оршин суухаар нэг улсын хилийг давж нөгөөд шилжин суурьших үйл явц юм. Гадаад шилжих хөдөлгөөнийг үл буцах ба буцах гэж ангилдаг. Буцах шилжих хөдөлгөөн нь шилжигч тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа өөрийн эх орондоо эргэж ирэхийг хэлнэ. Харин очсон улсдаа байнга оршин суухаар үлдэж байгаа бол уугуул эх орных нь хувьд үл буцах шилжих хөдөлгөөн болно. Мөн гадаад шилжих хөдөлгөөн нь **эмиграци** ба **иммиграци** гэсэн хоёр үндсэн ойлголтыг өөртөө багтаадаг. Эмиграци гэдгийн дор өөр улсад байнга оршин суухаар өөрийн улсаас гарч явахыг, иммиграци гэдэгт өөрийн эх орноос түр болон байнга оршин суухаар өөр улсад хүрэлцэн ирэхийг ойлгоно.

1995 оноос эхлэн Монгол иргэдийн гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, улмаар урсгал шинжтэй байснаа зохион байгуулалттай хэлбэрт шилжин орж

байна. Тухайлбал, Засгийн газар хоорондын гэрээгээр гадаадад суралцагчдын тоо жилээс жилд өссөн үзүүлэлттэй байгаа нь дараах баримтаас харагдаж байгаа юм. Манай улсаас гадаад орны их сургууль, коллежид 1996 оноос хойш жил бүр 180 гаруй оюутан, 58 магистрант, докторант хүлээн авагч талын зардлаар суралцаж байсан бол Япон, ОХУ, БНХАУ-ын Засгийн газраас өөрийн оронд суралцуулах монгол оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлснээр 2000-2001 оны хичээлийн жилд 231 оюутан, 70 магистрант, докторант суралцахаар элсжээ. Өнөөдөр гадаадад энэ шугамаар 1137 оюутан суралцаж байгаа гэсэн тоо байна. Гэтэл чухам албан бус замаар хичнээн хүн гадаадад суралцаж, ажиллаж амьдарч байгаа талаар улсын хэмжээнд бодитой статистик мэдээлэл алга байна.

Өнөөдөр хилийн чанадад сурч эсвэл ажиллахыг хүссэн олон хүмүүс, ялангуяа залуучууд байгаа нь нууц биш. Залуучууд, тэр тусмаа оюутнууд бол ерөнхийдөө хүн амын хамгийн хөдөлгөөнтэй хэсэг нь байдаг. Оюутнууд шинэ боломжийг ашиглахдаа хурдан, тэр тусмаа орчин үеийн паспортын чөлөөт тогтолцоо, ардчилал, чөлөөт байдлын үр дүнд гадаад орнуудад суралцах, мэргэжил дээшлүүлэх, аялах, зочлох зэрэг нь өргөн боломжтой болсон билээ. Иймээс оюутнуудын гадаад шилжих хөдөлгөөний ирээдүйн төлөв байдлын талаар мэдээлэл авах зорилгоор Монголын 12 томоохон их, дээд сургуулийн оюутнуудын дунд түүвэр судалгаа явуулсан юм.

### **Судалгааны зорилго**

Судалгааны гол зорилго нь, оюутнуудын гадаад шилжих хөдөлгөөний төлөв байдлыг тодорхойлох, түүнд нөлөөлж буй нийгэм, хүн ам зүй, гадаад орчны болон "татах" ба "түлхэх" хүчин зүйлүүдийг илрүүлэх явдал юм. Мөн түүнчлэн гадаад явах суваг, очихыг сонирхож буй улс орноо залуучууд хэрхэн тодорхойлдог талаар нэмэлт мэдээлэл олж авахыг зорилгоо.

### **Судалгааны арга зүй**

Түүвэр судалгаанд анкет асуулгын аргыг ашигласан ба 2001 онд эдийн засаг, техник, нийгмийн ба хүмүүнлэгийн, хөдөө аж ахуйн, анагаах ухааны зэрэг сургалтын янз бүрийн чиглэлээр суралцаж буй 1000 гаруй оюутнуудаас санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон судалгаанд хамруулав.


### **Судалгааны ач холбогдол**

Зохиогчийн бие даан явуулсан энэхүү судалгаа нь залуучуудын дотор хамгийн оюуны чадамжтай, мэргэжлийн бэлтгэгдсэн хэсэг болох оюутнуудын хилийн чанадад явах урсгал хөдөлгөөний ирээдүйн төлөв байдлын талаар гүнзгий төсөөлөлтэй болох боломж олгож байгаа юм.


### **Судалгааны үр дүн**

Оюутнуудын гадаад явах сонирхол, мөрөөдөл хэр зэрэг байгааг судлах зорилгоор "Та хилийн чанадад явах талаар эргэцүүлэн бодолхийлдэг үү" гэсэн асуултыг тавихад хариулагчдын 40 хувь нь үнэхээр их боддог, 47 хувь нь тийм санаа хааяа орж ирдэг гэж хариулсан байна (Зураг 1). Өөрөөр хэлбэл,

хариулагч оюутнуудын 90% орчим хувь нь гадаадад гарахыг сонирхож байна гэсэн үг. Харин энэ талаар ер боддоггүй эсвэл хариулахад хүндрэлтэй гэсэн оролцогчдын хариулт дөнгөж 12 хувийг эзэлж байна. Үүнээс харахад оюутан, залуучуудын гадаадад явах сонирхол их байдаг ажээ.



Оюутнуудын ирээдүйн гадаад шилжих хөдөлгөөний талаарх санал, бодлыг хүйсээр авч үзвэл гадаад шилжих хөдөлгөөнд эмэгтэй оюутнууд давамгайл оролцох төлөвтэй байна (Зураг 2).



Зурагаас харахад, эмэгтэйчүүдийн гадаад явах хүсэл сонирхол эрэгтэйчүүдийнхээс 8.3 пунктээр илүү байна. Харин эрэгтэйчүүдийн дунд гадаад явах талаарх асуудалд шийдэмгий бус хандаж буй байдал эмэгтэйчүүдийнхээс илүү ажиглагдаж байна.

Оюутнуудын гадаад оронд явах хүсэл тэмүүлэлд тэдний эцэг, эхийн боловсролын түвшин, мэргэжлийн бэлтгэл, гадаад хэлний мэдлэг, их, дээд сургуульд элсэхээс өмнө амьдарч байсан байршил хүчтэй нөлөөлж байна.

Ирээдүйд гадаадад явах хүсэлтэй хариулагчдын талаас илүү хувийнх нь эцэг, эхчүүд өндөр боловсролтой байхад бага буюу бүрэн бус дунд боловсролтой эцэг, эхтэй хариулагчид дөнгөж 7.4-8.7 хувийг эзэлж байна (Зураг 3).



Оюутнуудын их, дээд сургуульд элсэхээс өмнө амьдарч байсан байршлаас оюутнуудын гадаад шилжих хөдөлгөөний идэвх ихээхэн хамаарч байгаа нь сонирхол татаж байна. Улаанбаатар(48.9%) болон бусад томоохон хот, аймгийн төвөөс элссэн оюутнууд (26.2%)-ын хилийн чанадад явах хүсэл эрмэлзэл сумын төв, хөдөө амьдарч байсан оюутнуудаас бараг 5 дахин их байна. Эндээс харахад, хөдөөнөөс ирж суралцаж байгаа оюутнууд нь магадгүй ирээдүйд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудад амьдрах сонирхолтой байдаг болов уу.


Судалгаанд оролцсон, гадаадад явахыг хүсч буй оюутнуудын 40.5% нь өөрсдийн хүслийг биелүүлэхийн тулд тодорхой алхмууд хийж байгааг судалгааны дүн харууллаа. Тухайлбал, тэдний 35 хувь нь гадаад хэлийг эрчимтэй үзэж судалж байгаа, 28.6 хувь нь гадаадын их сургууль, коллежийн элсэлтийн тест болон шалгалт өгөхөөр бэлтгэж байгаа, 15.5 хувь нь хилийн чанадад амьдардаг ойр дотны ах дүү, найз нөхдөөсөө урилга хүлээж байгаа, 10.5 хувь нь олон улсын сангуудад хандаж байна. Түүнчлэн зарим нь олон улсын эрдэм шинжилгээний конкурсэд оролцох, гадаадын байгууллага болон элчин сайдын яамдуудад хандах зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг ч авч байгаа юм байна (Зураг4).



Оюутнуудын хилийн чанадад явах зорилго харилцан адилгүй байна. Судалгааны явцад олж авсан мэдээллээс харвал, оюутнуудын гадаад явах эрмэлзлийг гол төлөв мэргэжлийн сонирхол өдөөж байна.

Ирээдүйд гадаад орон руу явахыг хүсч буй гол зорилгоо, "цаашид үргэлжлүүлэн суралцахыг хүсч байгаа тул" гэж хариулагчид 55.9 хувь, "хэсэг хугацаанд гадаад оронд амьдрахыг хүсч байгаа" гэж хариулагчид 18.5 хувийг эзэлж байна.


Судалгаанд хамрагдсан, ирээдүйд гадаад руу явах сонирхолтой залуучуудаас 7.5% нь түр зуур ажиллах сонирхолтой байхад дөнгөж 2.9% нь гадаадад байнга оршин суухаар явах зорилготой байна. Харин 6.2% нь гадаадад явах зорилгоо дурын зорилгоор, дурын аргаар явах гэж хариулсан байх юм. Бидний үзэж байгаагаар, энэ хандлага гадаад орноор аялах, аливаа шинэ зүйлийг нүдээр үзэж мэдэх гэсэн залуу насны хүсэл тэмүүлэлтэй холбоотой болов уу (Зураг 5).



Монголын оюутан залуучууд бусад хөгжиж байгаа орнуудын залуустай ижил өндөр хөгжилтэй (АНУ, Япон, Англи, Австрали, Герман, Өмнөд Солонгос г.м) орнуудад явах хүсэлтэй байдаг. Судалгаанд оролцсон оюутнуудын 42.3% нь АНУ, 21.9% - Япон, 15% - Англи явах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Мөн түүнчлэн үнэ төлбөргүй сургалтын системтэй дэлхийн цөөхөн орны нэг Герман тэдний сонирхлыг ихээхэн хэмжээгээр татаж байгаа юм. Энд анхаарал татсан нэг асуудал бол нийт судалгаанд оролцсон оюутнуудын дотор 6.5% нь Монголоос л явж байвал ямар ч орон руу явахад бэлэн байна гэж хариулсан явдал юм. Энэ нь Монголд «түлхэх» хүчин зүйл их байгааг харуулж байна. Ийм түлхэх хүчин зүйлд цалин хөлсний болон нийгмийн хамгааллын түвшин бага, ажилгүйдэл их, манай их, дээд сургуулиудын сургалтын стандарт олон улсынхад нийцдэггүй зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлж байгааг тэд дурьджээ.

Өндөр хөгжилтэй орнуудын манай залуучуудыг татаж байгаа хүчин зүйлүүд бол цалин хөлсний өндөр түвшин, хүмүүсийн амьдрах нөхцөл илүү, соёлын өндөр түвшин зэрэг хүчин зүйлс ордог байна. Гэвч оюутнуудын хувьд татах хүчин зүйлийн бүтэц арай өөр байгааг судалгааны үр дүн харууллаа (Зураг 6). Асуулгад хариулагчдын 31.1 хувь нь боловсролын түвшингээ дээшлүүлэх, 22.8 хувь нь дэлхий ертөнцийг өөрийн нүдээр үзэх, 18.3 хувь нь соёлын өндөр түвшин гэж хариулсан байна. Мөн тэдний сонирхлыг татаж буй хүчин

зүйлүүдийн нэг бол ажил, амьдралын харьцангуй боломжтой нөхцөл (12.4%) ажээ.



Бидний судалгааны өөр нэг зорилго бол оюутнуудын гадаад орнуудад явах сувгийг судлах явдал юм. Оюутнууд бусад өндөр чадавх бүхий мэргэжилтнүүдийн нэгэн адил албан ёсны сувгийг илүүд үздэг нь судалгаанаас харагдлаа.

Нийт судалгаанд хамрагдсан оюутнуудын 38.7 хувь нь тэдний хувьд хамгийн боломжтой суваг бол албан ёсны сургалтын зөвшөөрөл авах явдал гэж үзэж байна. Үүнийг ч төр, засгаас дэмжиж, түүнд хамрагчдын тоо жилээс жилд өсөж байгаа талаар бид дээр өгүүлсэн билээ. Харин богино хугацаанд хилийн чанадад явахад хамгийн түгээмэл ашиглаж буй суваг нь зочлох хувийн урилга хүлээн авах хэмээн оролцогчдын 32 хувь үзсэн байна. Судалгаанд хамрагдагчдын 10 орчим хувь нь ажил олгогчтой гэрээ хийсний үндсэн дээр явах гэж хариулсан нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм. Эдгээрээс гадна, олонх оюутнуудын хувьд орчин үеийн мэдээллийн сувгийг ашиглан суралцах, дадлага хийх боломжийг эрж хайх, гадаадын янз бүрийн их сургууль, коллежи, олон улсын болон эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдэд хандан өргөдлийн маягт бөглөн явуулах зэрэг сувгуудыг өргөн ашигладаг байна. Эндээс, мэдээлэл бол гадаад шилжих хөдөлгөөнд түлхэц үзүүлж буй гол хүчин зүйл мөн гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

### Дүгнэлт

1. Гадаад орнуудад явах хүсэл сонирхол залуучуудын, ялангуяа оюутнуудын дунд маш өргөн тархсан байна гэдгийг дээрх судалгааны дүн харууллаа. Өндөр хөгжилтэй орнуудад, ялангуяа Барууны орнууд руу суралцах, ажиллах, амьдрах зорилгоор Монголын залуучуудын нэлээд хэсэг явахаар төлөвлөж байна.
2. Оюутнууд хилийн чанадад явахын тулд гадаад хэл эрчимтэй үзэх, олон улсын сангуудад хандах, олон улсын эрдэм сургууль, коллежийн элсэлтийн тест болон шалгалт өгөхөөр бэлтгэх, хилийн чанадад амьдардаг ойр дотны ах дүү, найз нөхдөөсөө урилга авах, олон улсын

уралдаан тэмцээнд оролцох, гадаадын байгууллага болон элчин сайдын яамдуудад хандах зэрэг тодорхой алхмуудыг хийж байна.

3. Оюутнуудын гадаад шилжих хөдөлгөөний ирээдүйн төлөв байдалд тэдний эцэг, эхийн боловсролын түвшин, их болон дээд сургуульд элсэн орохоос өмнө амьдарч байсан газар, мэдээлэл зэрэг хүчин зүйлс хүчтэй нөлөөлж байна.
4. Оюутан залуучуудын гадаад орнуудад явах зорилго харилцан адилгүй байгаагийн дотор цаашид үргэлжлүүлэн суралцах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, шинийг олж харах зэрэг нь хамгийн гол зорилго болж байна.

### **Шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд:**

1. Хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
2. Дотоод болон гадаад шилжих хөдөлгөөний бүртгэл мэдээллийг сайжруулж, ялангуяа албаны төдийгүй хувийн шугамаар гадаад орнуудад суралцаж, ажиллаж амьдарч буй хүмүүсийн тоо, мэдээлийг гаргах арга хэмжээ авах. Цаашид манай улсын иргэдийн хилийн чанадаас орж, гарч байгаа хөдөлгөөнийг хянах мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;
3. Гадаад орнуудад суралцаж, ажиллаж буй монгол иргэдийг, тэр тусмаа залуучуудыг эх орондоо эргэн ирж ажиллах сонирхлыг төрүүлэхийн тулд ажиллах орчин нөхцлийг бий болгох, тодорхой эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх.

### **Ном зүй:**

---

1. Сүхбаатар О. БНМАУ-ын хүн амын шилжих хөдөлгөөн, УБ, 1973
2. Гансүх П. Монгол улсын хүн ам зүйн менежмент, УБ, 2000
3. 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, УБ, 2001
4. ЭМНХЯ, МУИС-ийн ХАССТ. Дотоод шилжих хөдөлгөөний микро судалгаа, УБ, 2001
5. Переведенцев В.И. Методы изучения миграции населения. М., 1975
6. Рыбаковский Л.Л. Миграции населения, прогнозы, факторы, политика. М.: 1987
7. В.Кулаков. Пути регулирования миграционных процессов в Российской Федерации. Вопросы экономики, 1998, №5.